


# ЭЦСИЙН ШҮҮХ



## ЭЦСИЙН ШҮҮХ

Тэнгис, далай нас барагсдыг гаргаж ирэв. Үхэл болон үхдэлийн ертөнц нь өөртөө байгаа бүх хүмүүсийг гаргаж ирлээ. Тийнхүү бүх хүн дахин амилаад үйлдэж хийсэн бүх хэргийнхээ дагуу шүүгдсэн болно. Ингээд «үхэл» болон «үхдэлийн ертөнц» хамтдаа галт нууранд хаягдсан бөгөөд тийш орох нь хүний хоёрдахь үхэлтэй адил буюу. Улмаар мөнхийн амьдралтай болох хүмүүсийн нэрсийн жагсаалтад ороогүй бүх хүн тэрхүү галт нууранд хаягдав.

«Үзэгдэл» 20.13-15

Энэ бол Библийн үг. Хүн Ертөнцийн Эзэнээс эрүүл мэнд, эд хөрөнгө, амар хялбар амьдрал, аз жаргал, эхнэр нөхөр, үр хүүхэд гуйхыг гол зорилго болгох хэрэггүй. Үүний төлөө Их Эзэн Есүс Христ энэ дэлхийд ирээгүй юм. Харин хүний хүчээр хийх боломжгүй нэгэн онцгой чухал зүйлийг хийхээр ирсэн нь хүн төрөлхтний аврал билээ. Энэхүү аврал нь энэ дэлхийн амьдралтай огт холбоогүй бөгөөд харин „эцсийн шүүх“ гэж нэрлэгдсэн тэр нэгэн өдөртэй л холбоотой. Ертөнцийн Эзэн өөрөө хувь хүн бүрийн сэтгэл зүрх, бодол санаа, хүсэл зорилгыг төгс мэдэх бөгөөд хүн төрөлхтнийг бүтээхдээ үйлдэж хийсэн бүхнийг нь хариуцлагад тооцохоор төлөвлөсөн ажээ.

„Хүн эргэлт буцалтгүйгээр нэг л удаа үхээд дараа нь Ертөнцийн Эзэний шүүхээр орох ёстой“ гэсэн энэ үг Библид бий. («Еврейчүүд» 9.27) Нас барсан хойноо хэн ч энэхүү шүүхийн гамшигт үр дүнгээс зугтан зайлж чадахгүй учраас амьд байхдаа л үүнээс гарах боломжийг нь Ертөнцийн Эзэн өөрөө тавьж өгсөн байна.

Өөрийг нь хүн төрөлхтөн үл ойшоож явсан тэр үеийг Ертөнцийн Эзэн уучлан өнгөрүүлээд одоо харин хорвоо дэлхийд амьдарч буй хүн бүрт гэмт амьдралаасаа салах тушаалыг өгч байна.

«Үйл явдал» 17.30

Энэхүү тушаал нь өнөөдөр ч үндэстэн бүхний хувьд хүчин төгөлдөр бөгөөд хүний нийгэм оршин тогтнож буй цагт хувь хүн бүрийн хамгийн чухал асуудал нь байх ёстой.

**Хүн даян дэлхийг өөрийн болговч мөнхийн амьдралыг алдаад ямар ашиг байна? Хүн тийнхүү амь насаа алдсан бол, ямар үнээр түүнийгээ эргүүлэн авч чадах вэ? «Матай» 16.26**

Энэ үгийг нэгэнт сонссон хүн Ертөнцийн Эзэнээс аврал олохоос нааш санаа амрах ёсгүй юм. Энэ бол хувь хүн энэ дэлхийд амьдарч байхдаа эд хөрөнгө хураах, орон байртай болох, үр хүүхдээ өсгөн бойжуулах, амьдралын баталгаатай болох зэрэг өдөр тутмын санаа тавьдаг зүйлээс нь илүү ноцтой бөгөөд хүний амьдралын эцсийн зорилго нь ямар байх ёстойг сануулдаг үгс билээ.

**Учир нь, тэр өөрийнхөө сонгож томилсон хүнээр хүн төрөлхтнийг шударга ёсны үндсэн дээр шүүлгэх өдрийг товлон тогтоосон ажээ. Тийм шүүх гарцаагүй болно гэсэн баталгааг хүн төрөлхтөнд гаргахдаа тэр өөрийнхөө томилсон хүнийг алагдахад нь дахин амилуулсан болой. «Үйл явдал» 17.31**

**Ертөнцийн Эзэний илгээсэн хүн эцгийнхээ сүр жавхланг харуулан ер бусын элч нарынхаа хамт энэ дэлхийд дахин ирэхдээ хүн бүрийн хийсэн үйлд нь тохирсон хариуг өгөх болно. «Матай» 16.27**

Хүн төрөлхтөн тийнхүү Ертөнцийн Эзэний шүүхээр орох учраас түүний тавьсан шаардлагын дагуу амьдарч чадаагүй хүн өөрийгөө аврал олчихлоо гэж итгүүлэх нь жинхэнэ төөрөгдөл юм. Авралын тухай худал үгээр, шашны төөрөгдлөөр хүн өөрийгөө тайвшруулан тайтгаруулах хэрэггүй. Ийм санааг хүн өөрөө өөртөө төрүүлээд ямар ч ашиггүй. Яагаад гэвэл, хүн өөрийнхөө гаргасан шийдвэрээс болоод бус харин Ертөнцийн Эзэний шийдвэрээс болоод л аврал олдог. Тиймээс аврал олсон баталгааг нь хувь хүнд зөвхөн Ертөнцийн Эзэн л өгч өөрийнхөө шаардсан үнэнч шударгын замаар хөтлөн дагуулдаг болой. Түүний үгийг ноцтойгоор авч үзэн гэмээсээ салах энэхүү тушаалыг нь хүн төрөлхтөнд үе уламжлан, эрин зууныг дамжуулан сануулсаар байх үүргийг Есүс Христ өөрийнхөө хүмүүст өгчээ.

Та нар даян дэлхийгээр явж, Ертөнцийн Эзэний авралын тухай тунхгийг бүх хүн төрөлхтөнд зарлан тараагтун! Энэ тунхагт итгээд улмаар итгэснээ батлан усаар угаалгасан хүн аврагдах болно. Харин итгээгүй хүн яллуулан шийтгүүлнэ.

«Маарх» 16.15—16

Энэ үг нь ямар нэгэн шашны бүлэг өргөжин тэлэх, түүнийх нь үндсэн дээр хэсэг бүлэг хүмүүс амьжиргаагаа залгуулах ажилтай болох гэх мэт хүний зохион байгуулсан үйл хэрэгтэй огт холбоогүй бөгөөд харин хувь хүн бүрийн мөнхийн хувь тавилан хэрхэн шийдэгдэхийг нь харуулдаг үгс болно.

Хэрвээ хүн Ертөнцийн Эзэнийг зөв аргаар эрэн хайвал олно. Яагаад гэвэл „Ертөнцийн Эзэнээс гуйсан бүхэн түүнээс хариугаа авна. Ертөнцийн Эзэнээс эрсэн бүхэн түүнийгээ олно. Орох газрынхаа үүдийг тогшсон бүхэнд тэр үүд хаалгыг нь нээж өгнө“ гэсэн үг Библид бий. («Матай» 7.8) Харин таны хувьд гэвэл хамгийн чухал юмаа гуйх, хамгийн чухал юмаа эрэн хайх, хамгийн чухал газартаа орох гэж үүдийг нь тогших эсэхээ шийдэх асуудал бий. Бусдыг нь Ертөнцийн Эзэн өөрөө шийдэх болно.

Хүний амьдралын эцсийн зогсоол хаана төгсдгийг мэдэхийн тулд та орчлон ертөнц болон хүн төрөлхтнийг бүтээсэн эзэн нь болох Ертөнцийн Эзэний сануулж хэлсэн үгс буюу Библийг заавал унших хэрэгтэй.



Холбоо барих хаяг: [bsmongolia@gmail.com](mailto:bsmongolia@gmail.com)  
Лавлах утас: 9967-8732, 9981-9947

© 2019 Монголын Библийн Нийгэмлэг  
Хавтасны нүүрийн зургийг — © Corbis



[www.inyourlanguage.org/mongolian](http://www.inyourlanguage.org/mongolian)